

Өвөрхангай аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны 2023 оны дотоод аудитын төлөвлөгөө болон аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдөр баталсан 29/02 тоот удирдамжийн дагуу Өв-Эко мийт ОНӨХХК-ийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж гүйцэтгэлээ.

1.Аудитын зорилго:

Өв-Эко мийт орон нутгийн өмчит ХХК-ийн төсөв санхүүгийн үйл ажиллагаа үр ашигтай төлөвлөгдөж, зарцуулагдаж байгаа эсэх, ашигт ажиллагааг сайжруулах чиглэлээр хийгдсэн ажлын үр дүн, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд үр нөлөөтэй дотоод хяналтууд хэрэгждэг эсэх, санхүүгийн үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, шилэн данс хөтлөлт чанартай хийгдэж байгаа эсэх зэрэгт үнэлэлт дүгнэлт хийх, илэрсэн асуудал болон ашигт ажиллагааг сайжруулах чиглэлээр зөвлөгөө өгөх.

2.Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт:

Энэ удаагийн дотоод аудитыг зөвхөн санхүүгийн үйл ажиллагаанд чиглүүлэхийг зорьсон, мөн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн цаг хугацаанд аудитыг багтааж, үр дүнг тайлагнах шаардлагатай тул байгууллагын засаглалын бүтэц, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцыг бүхэлд нь авч үзэхгүй зөвхөн санхүүгийн үйл ажиллагаатай холбогдох хэсгийг хамруулна. Мөн Төрийн аудитаас санхүүгийн тайлан нь нягтлан бодох бүртгэлийн зарчим, стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд аудит хийж дүгнэлт өгөгдөх тул санхүүгийн тайлагналын хэсгийг хамруулахгүй.

№	Илэрсэн асуудлууд	Өгсөн зөвлөмж
1	Компанийн гүйцэтгэх захирал нь удирдах зөвлөлтэй гэрээ байгуулаагүй, ажлыг нь үнэлж дүгнэдэггүй, үйл ажиллагаа нь урсгалаараа явагддаг.	1. Компанийн дүрмэнд өөрчлөлт оруулж, удирдах зөвлөлийн эрх хэмжээ, чиг үүргийг нарийвчлан тусгаж өгөх 2. Удирдах зөвлөл ажиллах журмаа боловсруулан, баталж мөрдөж ажиллах 3. Гүйцэтгэх захирал Удирдах зөвлөлтэй гэрээ байгуулж, ажлын үр дүнг тооцон, урамшуулах хариуцлага тооцох зэрэг арга хэмжээг авч ажиллах

		<p>4. Гэрээний дагуу үйлдвэрийн үйл ажиллагааг тогтмол хэвийн явуулахаар ажлаа төлөвлөж, хэрэгжүүлэх зохин байгуулалтын арга хэмжээг авах</p> <p>5. Орон нутгийн өмчийн ашиглалт, үйлдвэрлэлийн хүчин чадлыг бүрэн дүүрэн ашиглах талаар санал санаачлагатай ажиллах</p>
2	Удирдах зөвлөл нь 2022 оны санхүүгийн төлөвлөгөөг батлаагүй, батлагдаагүй үнэ тарифаар үйлчилгээ үзүүлдэг.	<p>1. Компанийн бизнес төлөвлөгөөг орон нутгийн бодлого шийдвэртэй уялдуулан жил бүр баталж, биелэлтэд нь улирал тутам хяналт тавьж ажиллах</p> <p>2. Компанийн үйлчилгээний үнэ тарифыг зах зээлийн судалгаа хийсний үндсэн дээр батлах, жил бүр зах зээлийн тооцоо судалгааг хийж, үнэ тарифандаа өөрчлөлт оруулж батлан ажиллах</p> <p>3. Удирдах зөвлөл батлагдсан үнэ тарифыг мөрдөн ажиллаж байгаад хяналт тавьж ажиллах</p> <p>4. Орлогоо нэмэгдүүлэх боломжуудыг судлан, эдийн засгийн тооцоо судалгааг хийж, жил бүрийн бизнес төлөвлөгөөнд тусган Удирдах зөвлөлөөр батлуулан ажиллах</p>
3	Гүйцэтгэх захирал ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргалгүйгээр ажлын гэрээнүүдийг байгуулдаг.	<p>1. Гүйцэтгэх захирал гэрээ байгуулахдаа ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг заавал гаргаж хэвших</p> <p>2. Дээрх гаргасан мэдэгдлийг тухай бүрд нь хуулинд заасны дагуу шилэн дансны мэдээлэлд тогтмол байршуулан ажиллах</p> <p>3. Мах худалдан авах, борлуулах гэрээ байгуулахдаа үйлдвэрийн дарга, нягтлан бодогчийг заавал оролцуулах</p> <p>4. Хамтран ажиллах иргэн, аж ахуй нэгжтэй байгуулсан гэрээний хэрэгжилтэд Удирдах зөвлөл хяналтыг тогтмол тавьж ажиллах</p>
4	Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэггүй.	<p>1. Эрсдэлийн удирдлагын бодлого, журамтай болох</p> <p>2. Компанийн ажилтан, албан хаагчдад эрсдэлийн талаар ойлголт өгөх</p> <p>3. Жил бүр компанийн үйл ажиллагаа, дотоод гадаад хүчин зүйлс болон санхүүгийн зорилтуудад учрах эрсдэлийг шинэчлэн тодорхойлж, тохиолдох</p>

		<p>магадлал учруулах үр дагавраар нь үнэлэх, албажуулах</p> <p>4. Эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, үр дүнг тооцож ажиллах</p> <p>5. Нэг албан тушаалтныг эрсдэлийн удирдлагаар сургаж мэргэшүүлэх, чадавхижуулах</p> <p>6. Гүйцэтгэх удирдлага нь байгууллагын хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэхдээ эрсдэлийн чиглэлээр ур чадвар бүхий ажилтанг сонгон шалгаруулж авах</p> <p>7. Компанийн эрсдэлийн түвшинг үнэлэн шатлал ахиулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх</p>
5	<p>Дотоод хяналт шалгалтыг ор нэр төдий хийдэг. Үйл ажиллагаанд тавих хяналт сул.</p>	<p>1. Компанийн эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан дотоод хяналтын нэгжийн хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжүүлэн үр дүнг тооцож ажиллах</p> <p>2. Дотоод хяналтын журманд дотоод хяналтыг эрсдэлд суурилсан байдлаар зохион байгуулах, байгууллагын ямар үйл ажиллагааг хамруулах, хяналтыг хэрхэн хэрэгжүүлэх талаар тусгаж, дотоод хяналтын нэгж үр ашигтай ажилласан тохиолдолд хуулийн хүрээнд шагнаж урамшуулах хөшүүргийг бий болгох</p> <p>3. Компанийн дотоод хяналтын зураглалтай болж хамт олноороо мөрдөж, тасралтгүй ажиллах системийг бүрдүүлэх.</p>
6	<p>Анхан шатны баримтын бүрдэл дутуу.</p>	<p>1. Бараа материалын нэр төрөл бүрээр агуулахын бүртгэлийг хөтлөн, орлого, зарлагын хөдөлгөөнийг хийж, бараа материалын тайланг гарган нягтлан бодогчоор хянуулахдаа агуулахын үлдэгдэлтэй тулган баталгаажуулж байх</p> <p>2. Бичиг хэргийн материал, аж ахуйн материал, тээвэр шатахуун, махны тайлан зэрэг бараа материалын тайланг батлагдсан маягтаар улирал бүр нэр төрлөөр нь дэлгэрэнгүй гарган, нягтлан бодогчид хүлээлгэн өгч, хянан баталгаажуулж байх</p> <p>3. Бараа материалын үлдэгдэлд тооцоо бодсон актыг үйлдэж хэвших</p>

		<p>4. Автотээврийн хэрэгслийн техник ашиглалтын паспортад авсан, зарцуулсан шатахуун болон машин механизмын гүйцэтгэсэн ажлыг бүрэн гүйцэд бичилтийг хийж хэвших</p> <p>5. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, анхан шатны баримт бүрэн гүйцэд бүрдсэний дараа ажил гүйлгээг бүртгэж байх, тус оны анхан шатны баримт бүрдэл дутуу баримтыг бүрэн бүрдүүлэх</p> <p>6. Бэлэн мөнгөний орлого, зарлага, өглөг, авлага, бараа материалын журнал, ерөнхий дэвтрийг бүрэн гүйцэд хөтлөн санхүүгийн тайланг НББОУСтандартын дагуу гаргаж хэвших</p> <p>7. Нягтлан бодогч нярвыг мэргэжил арга зүйгээр хангаж, үйл ажиллагаанд нь өдөр тутам хяналтыг хэрэгжүүлж ажиллах</p> <p>8. Мөнгөн кассаас худалдан авалт хийхдээ анхан шатны баримтыг (И-баримт) заавал хавсаргах, сар бүр кассын тайлан гаргаж, нягтлан бодогч хяналт тавьж хэвших</p>
7	Харилцагч аж ахуйн нэгж байгууллага, иргэнтэй өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.	<p>1. Харилцагч байгууллага, иргэдтэй тооцоо нийлсэн актыг үйлдэж өр, авлагаа баталгаажуулж байх</p> <p>2. Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн холбогдолтой хууль, журам, заавартай сайтар танилцаж судлах</p> <p>3. Удаан жилийн насжилттай авлагыг шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлэн барагдуулах, зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах</p> <p>4. Өрөө бууруулахын тулд орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлэх ямар боломж бололцоо байгааг судлан тооцоо судалгааг хийн хэрэгжүүлэх ажлуудыг шат дараатайгаар авч хэрэгжүүлэх</p> <p>5. Орсон орлого, барагдсан авлага зэргээс өр төлбөрөө төлөх ажлуудыг хийж, өглөгөө бууруулж ажиллах</p>
8	Шилэн дансанд улирлын мэдээгээ илгээдэггүй, мэдээллийг хугацаа хоцроож болон зарим	<p>1. Шилэн дансны цахим системд мэдээллийг чанартай, цаг хугацаанд нь бүрэн оруулж хэвших</p> <p>2. Улирлын мэдээг хугацаанд нь тогтмол илгээж ажиллах</p>

	<p>мэдээг мэдээлдэггүй.</p> <p>огт</p>	<p>3. Шилэн дансны цахим системд мэдээлэл байршуулалт, илгээлт, мэдээллийн чанарт удирдлага, дотоод хяналтын нэгж тогтмол хяналт тавьж ажиллах.</p> <p>4. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг холбогдох албан хаагчийн ажил дүгнэх үзүүлэлтэд оруулан үр дүнг тооцон ажиллах, ажлын үзүүлэлт муу гарсан тохиолдолд хариуцлага тооцдог байх</p>
	<p>Нийт өгсөн зөвлөмж</p>	<p>40</p>